



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

“ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС



ДОТООДЫН ХЯНАЛТ САЙЖРУУЛЖ, ҮР АШИГГҮЙ ЗАРДЛЫГ
БУУРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

АУДИТЫН КОД: БӨА-2025/33-ШТА-ГА

2025 он

● БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Баян-Өлгий аймгийн ЦШСГ” ОНӨААТҮГ-ын талаар



Аудитаар нийт
8,982.1 сая төгрөгийн
зөрчил илэрсэн.



71.7 САЯ ТӨГРӨГИЙН 8
ТӨЛБӨРИЙН АКТ



6,916.2 САЯ ТӨГРӨГИЙН
5 АЛБАН ШААРДЛАГА



23,9 САЯ ТӨГРӨГИЙН
ЗӨРЧИЛД 6 ЗӨВЛӨМЖ



1,970.3 САЯ ТӨГРӨГИЙН
ЗӨРЧЛИЙГ ХУУЛИЙН
БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛСЭН



7042-2954,
7042-2930



www.audit.mn
www.open.audit.mn

● БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн “Суат” ХХК-ны талаар



Аудитаар нийт 422.3 сая
төгрөгийн зөрчил илэрсэн.



9.4 САЯ ТӨГРӨГИЙН 3
ТӨЛБӨРИЙН АКТ



412.9 САЯ ТӨГРӨГИЙН 5
АЛБАН ШААРДЛАГА



6 ЗӨВЛӨМЖ



7042-2954,
7042-2930



www.audit.mn
www.open.audit.mn



“ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”

ДҮГНЭЛТ

ОНӨААН-үүдийн засаглал, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар үр дүнтэй бодлого, шийдвэр гаргаж ажиллаагүй байна.

Үйл ажиллагааны эдийн засгийн үзүүлэлтүүдийг бодитой төлөвлөөгүй, зорилт түвшний зарим үзүүлэлтийг хангаж ажиллаагүй байна

Удирдлагын зардлыг тусад нь төлөвлөж, үр ашигтай зарцуулах талаар хангалтгүй ажилласан байна

Үйл ажиллагааны зардлыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, үр ашиггүй зардлыг бууруулах талаар хангалтгүй ажилласан байна

ЦШСГ-ын тендерийн орлого, зардлын бүртгэлийг үнэн зөв хөтөлж, ашигт ажиллагааг тооцож тайлагнаагүй байна

Худалдан авах ажиллагааг зохих журмаар төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна

Дотоодын хяналтыг үр нөлөөтэй төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна



● ТӨРИЙН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

I. Цахилгаан шугам сүлжээний газрын дарга /Ө.Арманбек/-д:

Үйл ажиллагааны орлого, зардлыг үндэслэлтэй төлөвлөх, удирдлагын зардлыг тусад нь төлөвлөх, бизнес төлөвлөгөө, хүрэх түвшнийг эдийн засгийн үзүүлэлт тус бүрээр ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар батлуулж ажиллах;

Үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, ашигт ажиллагааг дээшлүүлэхэд анхаарах;

Бусад орлогыг санхүүгийн тайланд үнэн зөв тусгах, Үйлдвэрчний эвлэлийн орлого, зарцуулалтын тооцоог баталгаажуулж байх;

Ажиллагсдын ажлыг үнэлэх, дүгнэх журам баталж, ажлын үр дүнг бодитой дүгнэж байх;

Байгууллагын дотоод хяналт шалгалтын журмыг шинэчлэн баталж, дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх;

II. “Сүэт” ХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Нурбек/-д:

Компанийн орлого, зардлын эдийн засгийн үзүүлэлтүүдийг үндэслэлтэй төлөвлөж, батлуулах;

Төсөвт байгууллагын усны төлбөрийг тоолуурын заалтаар авах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, төлбөрт үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах;

Зардал хэмнэх, үр ашиггүй зардлыг бууруулах, ашигт ажиллагааг дээшлүүлэхэд анхаарах;

Дотоод хяналтыг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах;

III. Цахилгаан шугам сүлжээний газрын Төлөөлөн удирдах зөвлөлд:

Цахилгаан шугам сүлжээний газрын засаглал, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар бодлого, шийдвэр гаргаж ажиллах

IV. Цахилгаан шугам сүлжээний газрын Төлөөлөн удирдах зөвлөлд:

Компанийн эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавьж ажиллах, үр ашгийг дээшлүүлэх;

Компанийн гүйцэтгэх захиралд үр чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулж батлах;



Эх сурвалж: Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар.
“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцОрон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.”
(2025 он)